| тушаалын бүртгэлийг АХХН-ҮЖ-д заасан батлагдсан загварын дагуу цахим хэлбэрээр хөтлөх.                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | мэргэжилтэн<br>Г.Ган-Эрдэнэ                              | хөтлөн хадгаламжийн нэгж үүсгэн архивд шилжүүлэн ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                             | 100% |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| <b>ХОЁР.БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| <b>2.1. Байгууллага болон нэгжийн удирдлага Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Хадгаламжийн санд тавигдах стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |      |
| 31                                                                                                                                                                                                                      | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 24 зүйлийн 24.1.1, 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3, 23.2.4, 23.2.5, 23.2.6, 23.2.7, 23.2.10, 23.4, "АХХНҮЖ"-ын 8.1.20-д заасны дагуу танай байгууллага орон тооны архивын ажилтантай боловч 2020-2024 онд 6 удаа өөрчлөгдсөнөөр байгууллагын архивын үйл ажиллагаа алдагдаж байгаа тул цаашид архивын ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах, мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах;                                                                                       | Хүний нөөцийн мэргэжилтэн<br>Б.Ундрал                    | НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулдаг архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтад тогтмол хамруулан ажиллахаар төлөвлөж байна.                                                                                                                                                                                                                     | 50%  |
| 32                                                                                                                                                                                                                      | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-ын 1 дүгээр хавсралтын 4.40 дэх заалтыг үндэслэн байгууллагын Дотоод журамд архивын ажилтны хөдөлмөр зохион байгуулалт, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах хүрээнд хүнд хортой нөхцөлийн нэмэгдэл олгох заалтыг тусган, нэмэгдлийг хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн тогтоон олгох; | Хүний нөөцийн мэргэжилтэн<br>Б.Ундрал                    | Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтний ажлын байр нь хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамрахгүй. Байгууллагын дотоод журамд архивын ажилтны хөдөлмөр зохион байгуулалт, ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах хүрээнд нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт оруулахаар ажлын хэсэг ажиллаж байна. | 70%  |
| 33                                                                                                                                                                                                                      | "БАУАНЖ"-ын 4.9-д заасны дагуу байгууллагын архивын баримтыг нягтлан шалгаж хадгалах хугацаагаар нь ангилан байнга, түр, 70 жил хадгалах, цахим болон тусгай төрлийн баримтын данс, бүртгэл жагсаалтыг хянаж батлах;                                                                                                                                                                                                                                                                                                                             | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн<br>Г.Ган-Эрдэнэ | 2025 оны байгууллагын архивын баримтын хадгалах хугацаагаар ангилан данс бүртгэлийн жагсаалтыг БНШК-ын хурлаар танилцуулан даргаар батлуулан ажиллаж байна.                                                                                                                                                                                                                 | 100% |
| 34                                                                                                                                                                                                                      | Хадгаламжийн санд тавигдах шаардлага MNS6929-1:2021 стандартын 4.2, "БАУАНЖ"-ын 6.2-т заасны дагуу Архивын баримтыг зориулалтын байранд хадгалах нөхцөлийг бүрдүүлж мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах;                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн<br>Г.Ган-Эрдэнэ | Хадгаламжийн сангийн стандарт, архивын баримтыг зориулалтын байранд хадгалах, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулахад тулгамдаж байгаа асуудал нь: манай байгууллага нь түрээсийн байртай, тухайн өрөө тасалгааг гаргах боломжгүй боловч өөрийн нөөц                                                                                                                   | 50%  |

|                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |      |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                | боломжид тулгуурлан нөхцөл орчныг бүрдүүлэн ажиллахыг эрмэлзэж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |      |
| 35                                                                                                                                                                        | "БАҮАНЖ"-ын 6.14.2, 6.14.5-д заасны дагуу архивын өрөөнд эрүүл ахуйн дэглэм мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх, жил бүрийн төсөвт архивт шаардлагатай зардлыг тусгаж шийдвэрлэх;                                                                                                                                                                                                                                          | Ерөнхий нягтлан<br>Г.Гэрэлтуяа                                 | Мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэх, жил бүрийн төсөвт архивд шаардлагатай зардлыг Санхүү, хөрөнгө оруулалтын албанаас тусгаж шийдвэрлэн ажиллаж байна. Тухайлбал: 2025 оны төсөвт 1,500,000 /нэг сая таван зуун төгрөг/, 2026 оны төсөвт 1,500,00 /нэг сая таван зуун төгрөг/ тус тус тусган ажиллаж байна.<br>Архив, албан хэргийн мэргэжилтэн архивын өрөөнд эрүүл ахуйн дэглэм мөрдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин жиллаж байна. | 90%  |
| 36                                                                                                                                                                        | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын 7.6.4-д заасны дагуу Ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримт, ажлын файлыг актаар хүлээлцэх, ажил хүлээлцэх ажлын хэсэгт архивын ажилтныг оролцуулах, Архивын ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд архивын баримтад иж бүрэн тооллого хийж актаар хүлээлцэхэд хяналт тавих | Хүний нөөцийн<br>мэргэжилтэн<br>Б.Ундрал                       | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"- 6 ын 2.2, 3.1.3, "БАҮАНЖ"-ын 7.6.4-д заасны дагуу архив, бичиг хэргийн ажилтныг ажлын хэсэгт томилон, цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримт, ажлын файлыг актаар цаашид тогтмол хүлээлцүүлэх, хяналт тавин ажиллах талаар анхааран ажиллаж байна.                                                | 70%  |
| 37                                                                                                                                                                        | "БАҮАНЖ"-ын 7.2, 7.6, 7.6.1, 7.6.2, 7.6.3, 7.6.4, 7.6.5-д заасны дагуу тооллогын удирдамж, төлөвлөгөө баталж архивын баримтад тооллого явуулах ажлын хэсэг байгуулан хэрэгжилтэд хяналт тавих;                                                                                                                                                                                                                                                                                         | Архив, бичиг<br>хэрэг хариуцсан<br>мэргэжилтэн<br>Г.Ган-Эрдэнэ | 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/38 байгууллагын даргын тушаалаар байгууллагын архивын баримтанд тооллого хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, тооллого хийх удирдамжийг батлан нийт 132800 хуудас бүхий 543 хадгаламжийн нэгжийг тоолсон.                                                                                                                                                                                                                        | 100% |
| <b>2.2. Байгууллагын ажилтан, албан хаагч Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |      |
| 38                                                                                                                                                                        | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын 1.3.1, 3.1.3, журмын 2 дугаар хавсралтын дагуу Ажилтан ажлаас чөлөөлөгдсөн                                                                                                                                                                                                                                                   | Хүний нөөцийн<br>мэргэжилтэн<br>Б.Ундрал                       | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ийн, 1.3.1, 3.1.3, журмын 2 дугаар хавсралтын дагуу                                                                                                                                                                                                                                                          | 100% |

|                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |     |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                                                                                                                                                               | тохиолдолд цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримт, ажлын файлыг актаар хүлээлцэх;                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                             | ажлаас чөлөөлөгдсөн 8 албан хаагчийн нийт 36 цаасан баримт, 78 цахим файлыг актаар хүлээлцэн ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                         |     |
| 39                                                                                                                                                            | "АХХНЖ"-ын 2.5.6-д заасны дагуу албан хаагч нь ХХНЖ-д санал өгч хэвших;                                                                                                                                                                                                                                                                                                             | Бүх албан хаагчид                                                                           | Байгууллагын алба нэгж бүр өөрсдийн үйл ажиллагаатай албан бичгийг "АХХНЖ"-ийн 2.5.6-д заасны дагуу албан хаагч нь ХХНЖ-д санал өгч ажиллан хэвшиж байна. 2025 оны ХХНЖ-ийг батлан хэрэгжүүлж ажилласан.                                                                                                                                                                                                        | 70% |
| 40                                                                                                                                                            | "БАҮАНЖ"-ын 3.7-д заасны дагуу зохион байгуулалтын нэгж, ажилтан цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримтыг зөв ангилан төрөлжүүлж, архивт шилжүүлэх баримтын жагсаалт үйлдэж баталсан хуваарийн дагуу архивт шилжүүлэх;                                                                                                                                                    | Бүх албад хаагчид                                                                           | Архив, албан хэргийн мэргэжилтэн албан хаагчдаас архивын баримтыг хүлээн авахдаа "БАҮАНЖ"-ын 3.7-д заасны дагуу зохион байгуулалтын нэгж, ажилтан цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримтыг зөв ангилан төрөлжүүлж, архивд шилжүүлэх баримтын жагсаалт үйлдэж баталсан хуваарийн дагуу бүртгэн хүлээн авч ажиллаж байна.                                                                               | 60% |
| 41                                                                                                                                                            | "БАҮАНЖ"-ын 3.10, 5.3.1, 5.3.2, 5.3.3, 5.3.6, 5.3.7, 5.3.8, 5.3.9, 5.5, 5.7, 5.7.1, 5.7.2, 5.7.6, 5.12-д заасны дагуу баталсан ХХНЖ-ын дагуу бүрэн, хөтлөгдсөн, нэр төрөл хадгалах хугацаагаар зөв ангилсан, хавсралт бүрэн, хуудас дугаарласан, дотоод товьёг, баталгааны хуудас үйлдсэн, эх хувь баримтыг үдэж хавтаслан нүүр бичилт үйлдэж хадгаламжийн нэгж бүрдүүлэх;          | Бүх албад хаагчид                                                                           | Архив, албан хэргийн мэргэжилтэн ХХНЖ-ын дагуу бүрэн, хөтлөгдсөн, нэр төрөл хадгалах хугацаагаар зөв ангилсан, хавсралт бүрэн, хуудас дугаарласан, дотоод товьёг, баталгааны хуудас үйлдсэн, эх хувь баримтыг үдэж хавтаслан нүүр бичилт зөв хийсэн эсэхэд хяналт тавьж архивд өгөх баримт бичгийг хүлээн авч шаардлага хангаагүй баримтыг буцаан засуулж ажиллаж байна.                                        | 70% |
| <b>2.3. Байгууллагын Архивын ажилтан албан хэрэг хөтлөлтийн хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |     |
| 42                                                                                                                                                            | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын 1.3.1, 3.1.3, журмын 2 дугаар хавсралтын дагуу архивын ажилтан ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд цаасан болон цахим баримт, тусгай төрлийн баримтын акт үйлдэн архивын баримтад иж бүрэн тооллого хийж хүлээлгэн өгч хэвших; | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ<br>Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ундрал | Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/633 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн ажил хүлээлцэх журам"-ын 1.3.1, 3.1.3, журмын 2 дугаар хавсралтын дагуу архивын баримтад иж бүрэн тооллого хийж, нийт 36 цаасан баримт, 78 цахим файл хүлээлгэн өгч ажилласан байна. Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд архивын баримтанд | 70% |

|                                                           |                                                                                                                                                                                                                                                      |                                                             |                                                                                                                                                                                                                     |      |
|-----------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| 49                                                        | "БАҮАНЖ"-ын 6.5.4, 6.14.4-д заасны дагуу агааржуулалтын системийг жилд 1-ээс доошгүй удаа шалгаж цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хийж, хадгаламжийн санд цэвэрлэгээ үйлчилгээ хийсэн тухай бүртгэлийг хөтөлж хэвших;                                    | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ       | Архивын өрөөнд агааржуулалт хийн хадгаламжийн санд цэвэрлэгээ үйлчилгээ хийж тухайн бүртгэлийг журмын хавсралтад заасан загварын дагуу тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.                                              | 100% |
| 50                                                        | БАҮАНЖ"-ын 6.14.2, 6.14.5-д заасны дагуу архивын өрөөнд эрүүл ахуйн дэглэм мөрдөж албан хаагч нэвтрэх тохиолдолд удирдлагаас зөвшөөрөл авч, малгай, халаад, бээлий, улавч өмсөх, мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж хэвших | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ       | Архивын өрөөнд нэвтрэх зөвшөөрөл удирдлагаас авч малгай, бээлий, халаад, улавч өмсөх, халдваргүйжүүлэлт тогтмол хийн ажиллаж байна.                                                                                 | 90%  |
| 51                                                        | "БАҮАНЖ"-ын 10.6, 10.7-д заасны дагуу албан хаагчид архиваас албан ажлын хэрэгцээнд баримт ашигласан тохиолдолд түр олгосон баримт бүртгэл, ашиглалтын хуудсыг хөтлүүлж хэвших;                                                                      | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ       | Архивын баримт ашиглах тутамд тухайн баримтын ашиглалтын хуудсыг бүрэн хөтлүүлэн ажиллаж байна.                                                                                                                     | 90%  |
| 52                                                        | "БАҮАНЖ"-ын 6.5.3-д заасны дагуу аврах гарцын схем зураглалыг архивын өрөөнд байрлуулах;                                                                                                                                                             | Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Ган-Эрдэнэ       | Архивын байранд аврах гарцын схем зургийг байрлуулсан.                                                                                                                                                              | 100% |
| 53                                                        | "БАҮАНЖ"-ын 11.3-д заасны дагуу жил бүр түүхчилсэн лавлахад баяжилт хийж хэвших.                                                                                                                                                                     | Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Цэцэгмаа | Энэ жилээс эхлэн байгууллагын түүхчилсэн лавлагааг жил бүр хийхээр саналаа өгсөн. Үүнд алба албадаар нь зураг авах, шинэ ажилд орсон ажилтнуудын зургийг авч байгууллагын архивт баяжуулалт хийхээр төлөвлөж байна. | 50%  |
| 54                                                        | "БАҮАНЖ"-ын 18.9-д заасны дагуу цахим баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлэх, тээгчийн төрлийг нэмэгдүүлэх.                                                                                                                            | Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн Цэцэгмаа | Цахим баримтыг флаш болон хард дискт хуулан хадгалж байна. Баримтын багтаамжаас хамаарч тээгчийн төрлийг нэмэгдүүлж ажиллана.                                                                                       | 70%  |
| ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ         |                                                                                                                                                                                                                                                      |                                                             |                                                                                                                                                                                                                     |      |
| 3.1. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хүрээнд: |                                                                                                                                                                                                                                                      |                                                             |                                                                                                                                                                                                                     |      |
| 55                                                        | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж баталж хэрэгжүүлэх. Баримт бичигт шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр, хариуцах                                                                                                     | Тогтоол шийдвэрийн биелэлт                                  | Захиргаа, удирдлагын алба, Маркетинг хамтын ажиллагааны алба хамтран байгууллагын 2026                                                                                                                              | 60%  |

|                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |      |
|---------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
|                                                                                       | болон хамтран хэрэгжүүлэх газар, нэгжүүд болон дунд хугацаандаа төлөвлөлтийн уялдааг зөв тооцож, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлж тусгах;                                                                                                                                                                              | хариуцсан мэргэжилтэн Р.Солонго                                | оны стратеги төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |      |
| 56                                                                                    | Холбогдох журмын дагуу нэгж, хэлтэс, алба, албан хаагчид байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулах; Газар нэгж, ажилтнуудын төлөвлөгөө боловсруулах загварыг дотооддоо баталж мөрдүүлж болох бөгөөд хэрэгжүүлэх үйл ажиллагааг бодитой тооцож, томъёолох. | Бүх албад                                                      | Алба нэгж, албан хаагчид холбогдох журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан өөрсдийн төлөвлөгөөг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, баталгаажуулж хэвшсэн. Нийт 4 албаны төлөвлөгөө, тайланг зохих журмын дагуу хянан баталгаажуулж ажиллаж байна.                                                                                                      | 90%  |
| 57                                                                                    | Байгууллагын үйл ажиллагаа, стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; Хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажилтаны ажил үүргийг тодорхой болгох, мэргэшүүлж чадавхижуулах                                                                                                                                           | Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баттөгс | Байгууллагын 2025 оны хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хий ажилласан. 2025 оны хагас жилээр 78,04%, жилийн эцсийн байдлаар 92,09%-ийн гүйцэтгэлтэйгээр үнэлгээг хийж ажилласан. Ажилтны ажил үүргийг тодорхой болгох, мэргэшүүлж чадавхижуулах ажлыг идэвхжүүлэх ажлын хүрээнд хүний нөөцийн мэргэжилтний сургалт хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулан ажиллав. | 100% |
| <b>3.2. Байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд:</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |      |
| 58                                                                                    | Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахтай холбоотой ажлын байрны шинжилгээ хийх;                                                                                                                                                                                                                                            | Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ундрал                             | 2025 онд 15 ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулах санал гарган ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                         | 90%  |
| 59                                                                                    | Байгууллагын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа албан хаагчдын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн боловсруулах;                                                                                                                                                                                                                         | Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ундрал                             | Байгууллагын "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2022-2025"-ын хугацаа дуусаж, "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2026-2029"-ийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                              | 50%  |
| <b>3.3. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн түүний хэрэгжилтийн хүрээнд:</b>  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |      |
| 60                                                                                    | Албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтыг журмын дагуу хийх;                                                                                                                                                                                                                                                                    | Хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ундрал                             | Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг батлагдсан журмын дагуу бүрдүүлэлт хийж, хадгалалт, хавтаст хийн төмөр сейфт хадгалж ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                          | 100% |

|    |                                                                                                              |                                       |                                                                                                                                                                           |              |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| 61 | Шилжилт хөдөлгөөн хийсэн тухай бүртгэл үйлдэх, цахим системд албан хаагчдын мэдээллийг бүрэн гүйцэд оруулах. | Хүний нөөцийн мэргэжилтэн<br>Б.Ундрал | Хүний нөөцийн системд нийт ажилтан, албан хаагчдын мэдээлэл бүрэн бүртгэгдсэн байна. Нийт 35 албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн цахим системд бүртгэн ажиллаж байна. | 100%         |
|    | <b>ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ</b>                                                                              |                                       |                                                                                                                                                                           | <b>87,5%</b> |

Танилцсан:

Газрын дарга



/ Д.Отгонбаатар /

Хяналт хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн



/ Н.Баттөгс /

Боловсруулсан:

Тогтоол шийдвэр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн



/ Р.Солонго /